



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 09 -ны өдөр

Дугаар А/10

Эрдэнэт

“Баг томилох тухай”

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Коронавируст халдвар (COVID-19)-ын халдварын сэргийлэлтийг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн Сайдын 2020 оны А/135 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдвар ( COVID-19)-ын сэжигтэй тохиолдол илэрсэн үед шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдийн үүргийг хоёрдугаар хавсралтаар, Коронавируст халдвар (COVID-19)-ын тохиолдолтой ажилласан шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдийг халдвараас сэргийлэх, хянах, арга хэмжээний журмыг гуравдугаар хавсралтаар, Коронавируст халдвар (COVID-19)-ын үед Хувийн хамгаалах хэрэгслийг зохистой хэрэглэх түр зөвлөмжийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед дагаж мөрдөх тушаал шийдвэр, түр зөвлөмжүүд, мэргэжлийн байгууллагуудын заавар, удирдамжийг сайтар мөрдөж хариуцлагатай ажиллахыг багийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж тухай бүр тайлагнаж ажиллахыг Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн /Б. Билгүүнээ/-д даалгасугай .

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 03 сарын 02-ны  
өдрийн 110 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**Шуурхай хариу арга хэмжээний 1-р багийн бүрэлдэхүүн:**

№	Овог нэр	Албан байгууллага	Албан тушаал	Гишүүнчлэл
1	Б.Билгүүнээ	Эрүүл мэндийн газар	Тархвар судлаач	Ахлагч
2	Мөнхжаргал	БОЭТөв	Эмнэлзүйч эмч	Гишүүн
3	П.Жавхлан	Анхны оч ӨЭМТ	Сувилагч	Ариутгагч
4	Шинэ-Идэр	БОЭТөв	Жолооч	Жолооч

**Шуурхай хариу арга хэмжээний 2-р багийн бүрэлдэхүүн:**

№	Овог нэр	Албан байгууллага	Албан тушаал	Гишүүнчлэл
1	М.Уранчимэг	Медипас төрөлжсөн эмнэлэг	Тархвар судлаач	Ахлагч
2	Буянжаргал	БОЭТөв	Эмнэлзүйч эмч	Гишүүн
3	Ц.Оюунзул	Мэндцэцэн ӨЭМТ	Сувилагч	Ариутгагч
4	Баасанжаргал	БОЭТөв	Жолооч	Жолооч

**Шуурхай хариу арга хэмжээний 3-р багийн бүрэлдэхүүн:**

№	Овог нэр	Албан байгууллага	Албан тушаал	Гишүүнчлэл
1	Б.Энхтүвшин	Эрүүл мэндийн газар	Тархвар судлаач	Ахлагч
2	Буянхишиг	БОЭТөв	Эмнэлзүйч эмч	Гишүүн
3	Г.Байгальмаа	Энхжихмандирваа ӨЭМТ	Сувилагч	Ариутгагч
4	Энхбаатар	БОЭТөв	Жолооч	Жолооч

**Шуурхай хариу арга хэмжээний 4-р багийн бүрэлдэхүүн:**

№	Овог нэр	Албан байгууллага	Албан тушаал	Гишүүнчлэл
1	Б.Цэндбаяр	БОЭТөв	Тархвар судлаач	Ахлагч
2	Болормаа	БОЭТөв	Эмнэлзүйч эмч	Гишүүн
3	М.Болорцэцэг	Үйлсбадрах ӨЭМТ	Сувилагч	Ариутгагч
4	Баярболд	БОЭТөв	Жолооч	Жолооч

**Шуурхай хариу арга хэмжээний 5-р багийн бүрэлдэхүүн:**

№	Овог нэр	Албан байгууллага	Албан тушаал	Гишүүнчлэл
1	Г.Ангар	Эрдэнэт сувилалын цогцолбор	Тархвар судлаач	Ахлагч
2	Уянга	Мэндцэцэн ӨЭМТ	Эмнэлзүйч эмч	Гишүүн
3	Д.Номхон	Нийцэл ӨЭМТ	Сувилагч	Ариутгагч
4	Э.Дамдинрагчаа	Мэндцэцэн ӨЭМТ	Жолооч	Жолооч

## БАГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Багийн гишүүд дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд :

### Багийн ахлагч:

1. Багийн гишүүдийн хувийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах, ажлын болон амралтын цагийг зохицуулах, үйл ажиллагааг бусад багтай нийцүүлэх, хамтран ажиллах, мэдээ мэдээлэл солилцох ажлыг хариуцан, багийг нэгдсэн удирдлагаар хангана.
2. Дуудлага хүлээн авмагц багийн гишүүдийг цуглуулан, бэлэн байдлыг хангаж, дуудлага хүлээн авснаас хойш 20 минутын дотор сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн газар руу хөдөлнө.
3. Тухайн үеийн нөхцөл байдал, хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний тухай мэдээллээр удирдлага болон бусад багийн ахлагч нарыг хангана.
4. Багийн нэг өдөрт гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэн холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

### Тархвар судлагч их эмч:

1. Сэжигтэй тохиолдлоос тархвар судлалын асуумж (хавсралт 4)-ийн дагуу тандалт судалгаа хийж, тандалт судалгааны дүнд үндэслэн эмнэлзүйч эмчтэй зөвлөлдөн, өвчтөнийг тусгаарлах эсэхийг шийдвэрлэнэ.
2. Сэжигтэй тохиолдлын ойрын хавьтлыг судлан, гэрт нь тусгаарлаж, 14 хоногийн хугацаанд харьяалах сум, өрхийн эмчийн хяналтад хүлээлгэн өгнө.
3. Өвчтөн, сум, өрхийн эмч мэргэжилтэнд аргагүйн зөвлөмж, зөвлөгөөг өгнө.
4. Өвчтөн, түүний ойрын хавьтлыг тусгаарласан тухай мэдээллийг аймгийн ЭМГ, ӨЭМТ-ийн холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлнэ.
5. Сэжигтэй тохиолдол, ойрын хавьтлын дэлгэрэнгүй мэдээлэл, тархварзүйн дүгнэлтийг холбогдох нэгтгэн бүртгэнэ.

### Эмнэлзүйч эмч:

1. Сэжигтэй тохиолдлоос эмнэлзүйн асуумж авч, өвчтөний биеийн байдлын үнэлгээнд үндэслэн эмнэлзүйн урьдчилсан оношийг тавина.
2. Тархвар судлагчтай зөвлөлдөн өвчтөнийг тусгаарлах эсэхийг шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд анхны тусламжийг үзүүлнэ.
3. Сэжигтэй тохиолдлыг харьяалах эмнэлэгт урьдчилан мэдэгдэж, өвчтөнийг хүлээлгэж өгнө.
4. Хэрэв сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохироогүй бол тухайн иргэнд зөвлөлгөө өгнө.
5. Тухайн өдөр өөрийн гүйцэтгэсэн ажлын тайланг багийн ахлагчид хүлээлгэн өгнө.

### Лабораторийн эмч эсвэл лаборант:

1. Сэжигтэй тохиолдлоос сорьц авч, ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид илгээнэ.
2. Сорьц илгээсэн тухай мэдээллийг лабораторийн эрхлэгчид шууд мэдээлнэ.
3. Лабораторийн шинжилгээний хариуг авч, холбогдох албан тушаалтанд мэдээлнэ.
4. Тухайн өдөр өөрийн гүйцэтгэсэн ажлын тайланг багийн ахлагчид хүлээлгэн өгнө.

**Ариутгалын ажилтан:**

1. Халдварын голомтод эцсийн халдваргүйтгэлийг тархвар судлагч эмчийн зөвлөмжийн дагуу гүйцэтгэж, тэмдэглэл хөтөлнө.
2. Тухайн өдөр өөрийн гүйцэтгэсэн ажлын тайланг багийн ахлагчид өгнө.
3. Багийн гишүүдийг амраах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд багийн ахлагчид тусална.

**Жолооч:**

1. Машины бэлэн байдлыг хангана.
2. Багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангаж, замын хөдөлгөөний дүрмийг баримтална.
3. Тухайн өдөр өөрийн гүйцэтгэсэн ажлын тайланг багийн ахлагчид хүлээлгэн өгнө.

**Шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдийг халдвараас сэргийлэх,  
хянах, арга хэмжээний журам**

1. Багийн гишүүд өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх явцад хамгаалах хувцас өмсөөгүй, буруу өмссөн, хувцас урагдсан, гэмтсэн, биологийн шингэнд хамгаалалтгүй хүрсэн зэрэг халдвар авах эрсдэлд өртсөн тохиолдолд 14 хоногийн хугацаанд тусгаарлан, эмчийн хяналтад байлгаж, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг үндэслэн асуудлыг шийдвэрлэнэ.
2. Багийн гишүүд нь биеийн халуунаа өдөрт 2 удаа үзэж тэмдэглэнэ
3. Өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлсэн багийн гишүүдийг 7 хоногийн хугацаанд тусгаарлаж, биеийн байдлыг хянанэ.

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 04 сарын 09-ны  
едрийн 17 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

**Коронавируст халдвар (COVID-19)-ын үед Хувийн хамгаалах хэрэгслийг  
зохистой хэрэглэх түр зөвлөмж**

Нөхцөл байдал	Хувь хүн ба өвчтөн	Үйл ажиллагаа	Хувийн хамгаалах хэрэгсэл , ажилбар
<b>Хэвтэн эмчлэх хэсэгт хэрэглэх хувийн хамгаалах хэрэгсэл</b>			
Өвчтний өрөө	Эрүүл мэндийн ажилтан	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнтэй шууд харьцах	Эмнэлгийн маск Халад Бээлий Нүдний хамгаалалт (нүдний шил эсвэл нүүрний хаалт)
		Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнд аэрозол үүсгэх ажилбар хийх	N95 эсвэл FFP2 Халад Бээлий Нүдний хамгаалалт Хормогч
	Асрагч, үйлчлэгч	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтний өрөөнд орох	Эмнэлгийн маск Халад Цэвэрлэгээний зузаан бээлий Нүдний хамгаалалт (органик материал болон химийн бодис үсрэх эрсдлийн үед) Түрийтэй эсвэл ажлын битүү гутал
	Бусад хүмүүс	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтний өрөөнд орох	Эмнэлгийн маск Халад Бээлий
Өвчтөн дамжин өнгөрсөн бусад хэсэг (тасаг, коридор)	Эрүүл мэндийн ажилтан болон бусад хүн	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнтэй харьцахаас бусад үйл ажиллагаа	Амны хаалт
Хүлээн авах хэсэг /эрэмбэлэн ангилах/	Эрүүл мэндийн ажилтан	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнтэй шууд хүрэлцэхгүй зайнаас халуун үзэх, асуумж авах	Амны хаалт Бээлий Халад Малгай
	Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн хүн	Тусгаарлах өрөөнд зайнаас халуун үзэх, асуумж авах	1 метрээс дээш зай барин ажиллах. Амны хаалт Бээлий Халад Малгай
	Амьсгалын замын өвчнөөс бусад шинж тэмдэг илэрсэн	Зөвлөгөө өгөх, шаардагдах арга хэмжээг авах	Амны хаалт Бээлий Халад Малгай
Лабораторит	Лаборант	Амьсгалын замын эрхтнээс сорьц авах	Эмнэлгийн маск Халад Бээлий Нүдний хамгаалалт
Захиргааны	Эмнэлгийн болон	Коронавируст халдвар	Амны хаалт

хэсэгт	бусад хүн	(COVID-19)-тай өвчтөнтэй харьцахаас бусад ажил үүрэг	
<b>Амбулатори</b>			
Үзлэгийн өрөө	Эрүүл мэндийн ажилтан	Амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй өвчтөнд үзлэг хийх	Эмнэлгийн маск Халад Бээлий Нүдний хамгаалалт
		Амьсгалын замын өвчний шинж тэмдэггүй өвчтөнд үзлэг хийх	Эмнэлгийн маск Халад Бээлий
	Амбулатороор үйлчлүүлэгч	Бүх нөхцөлд	Амны хаалт
	Асрагч, үйлчлэгч	Амьсгалын замын өвчний хам шинжтэй өвчтний үзлэгийн дараа цэвэрлэгээ хийх	Эмнэлгийн маск Халад Зузаан бээлий Нүдний хамгаалалт (органик материал болон химийн бодис үсрэх эрсдлийн үед) Түрийтэй гутал эсвэл ажлын битүү шаахай
Хүлээлгийн танхимд үйлчлүүлэгчдийг ангилан, нэг метрээс хол зайтай суулгана.	Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгч	Өвчтнийг тусгаарлах өрөөнд оруулах	Эмнэлгийн маск
	Амьсгалын замын шинж тэмдэггүй үйлчлүүлэгч		Амны хаалт
Захиргааны хэсэг	Эмнэлгийн болон бусад хүн	Бусад ажил хэрэг	Амны хаалт
Угтах хэсэг /эрэмбэлэн ангилах/	Эрүүл мэндийн ажилтан	Зайнаас халуун үзэх, асуумж авах	Амны хаалт Бээлий Халад Малгай
	Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн хүн	Тусгаарлах өрөөнд зайнаас халуун үзэх, асуумж авах	1 метрээс доошгүй зайнаас ажиллах Амны хаалт Бээлий Халад Малгай
	Амьсгалын замын өвчнөөс бусад шинж тэмдэг илэрсэн	Зөвлөгөө өгөх, шаардагдах арга хэмжээг авах	Амны хаалт Бээлий Халад Малгай
<b>Эмнэлгээс бусад орчин</b>			
Гэрт	Амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй хүн	Өөрийгөө тусгаарлах Утсаар зөвлөгөө авах	Гэр бүлийн бусад гишүүдээс нэг метрээс доошгүй зайтай байх Амны хаалт зүүх
	Гэр бүлийн гишүүд	Зайнаас харьцах	Амны хаалт зүүх
	Өвчтнийг гэрээр асарч байгаа хүн	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтний ялгадас, өтгөн шингэнийг цэвэрлэх	Бээлий Амны хаалт Хормогч (шингэн үсрэх эрсдлийн үед) Нүдний шил
	Эрүүл мэндийн ажилтан	Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнтэй шууд харьцах,	Эмнэлгийн маск Халад Бээлий

		эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх	Нүдний хамгаалалт
Олон нийтийн газар (сургууль, дэлгүүр, галт тэрэгний буудал гэх мэт)	Амьсгалын замын өвчний шинж тэмдэггүй хүн	Бүх тохиолдолд	Амны хаалт
<b>Хилийн шалган нэвтрүүлэх хэсэгт</b>			
Захиргааны хэсэгт	Бүх ажилтан	Бүх тохиолдолд	Амны хаалт
Хяналтын хэсэг	Ажилтан /Онгоц, галт тэрэг, автомашин/	Эрүүл мэндийн асуумж авах, зайнаас халуун хэмжих	Амны хаалт Бээлий
	Ажилтан /Тусгаарлах өрөө/	Амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй зорчигчоос аяллын түүхийн асуумж авах	Эмнэлгийн маск Бээлий Халат
	Үйлчилгээний ажилтан	Тусгаарлах өрөө цэвэрлэх	Эмнэлгийн маск Халад Цэвэрлэгээний зузаан бээлий Нүдний хамгаалалт (органик материал болон химийн бодис үсрэх эрсдлийн үед) Түрийтэй гутал эсвэл ажлын битүү шаахай
Түргэний машин болон бусад тээврийн хэрэгсэл	Эрүүл мэндийн ажилтан	Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй өвчтнийг эмнэлэг рүү тээвэрлэх	Эмнэлгийн маск Халад Бээлий Нүдний хамгаалалт
	Жолооч	Сэжигтэй өвчтнийг тээвэрлэх	Амны хаалт
		Сэжигтэй өвчтөнд туслах үед	Амны хаалт Халад Бээлий Нүдний хамгаалалт
	Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй өвчтөн	Тээвэрлэх үед	Амны хаалт
	Жолооч, үйлчилгээний ажилтан	Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй өвчтнийг тээвэрлэсний дараа цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт	Амны хаалт Халад Цэвэрлэгээний зузаан бээлий Нүдний хамгаалалт (органик материал болон химийн бодис үсрэх эрсдэлтэй үед) Түрийтэй битүү гутал
<b>Шуурхай хариу арга хэмжээний баг</b>			
Бүх газарт	Шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүд	Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдол, түүний хавьтлуудтай ярилцлага хийх, асуумж авах	Алсын зайн буюу гар утас, видео дуудлага ашиглах
		Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон батлагдсан хүнээс биечлэн асуумж судалгаа авах	Амны хаалт Бээлий Малгай Халад 1 метрээс доошгүй зайд



		Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтний шинж тэмдэггүй ойрын хавьтлаас биечлэн асуумж судалгаа авах	харьцах 1 метрээс доошгүй зайд харьцах Амны хаалт Бээлий Асуумжийг гэрийн эсвэл хаалганы гаднаас хийх Зайнаас халуун үзэх Гэрийн эд зүйлд хүрэхгүй байх
--	--	---	---